



МОНГОЛ УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

Г Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аж ахуйн нэгж, байгууллагад Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах нормативыг дор дурдсанаар баталсугай.

а/. Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага 50-иас 100 хүртэл ажилтантай тохиолдолд нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтантай, 100-аас дээш ажилтантай тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэцтэй байна.

б/. Ажлын байрны эрсдэлийн түвшин ихтэй уул уурхай, эрчим хүч, зам, барилгын салбар болон үйлдвэрлэлийн аюултай, хортой хүчин зүйлс бүхий аж ахуйн нэгж, байгууллагад ажилтны тооноос хамаарахгүйгээр нэг ба түүнээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан ажиллуулна.

в/. Төрийн болон төрийн үйлчилгээний төсвийн байгууллага ажилтны тооноос хамаарахгүйгээр Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг аль нэг ажилтанд хавсран хариуцуулна. Хавсран ажиллуулсан тохиолдолд Хөдөлмөрийн тухай хуулийн 50 дугаар зүйлд заасны дагуу үндсэн ажлын цалингийн 40 хүртэлх хувийн нэмэгдэл хөлс олгоно.

г/. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2, 4.1.3, 4.1.6-д заасан аж ахуйн нэгж, байгууллага нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бүтэц болон ажилтан ажиллуулах орон тоонд хүрээгүй тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг мэргэшсэн байгууллага, ажилтнаар гэрээгээр гүйцэтгүүлж болно.

д/. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийг /орон тооны бус/ 20-иос дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага бүр байгуулж, ажиллуулна.

0000000667


2. Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журмыг хавсралтаар баталсугай.

3. Батлагдсан нормативын дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, зөвлөл ажиллуулан дүрмийг батлан мөрдөхийг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн харилцааны бодлого зохицуулалтын газар /Б.Алимаа/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан "Зөвлөл байгуулах, орон тооны ажилтан ажиллуулах норматив батлах тухай" Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2008 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 126 дугаар тушаал, Хөдөлмөрийн сайдын 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн А/32 дугаар тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ЧИНЗОРИГ

Хөдөлмөрийн сайдын 2015 оны 06 дугаар
сарын 22-ны өдрийн 14 дугаар
тушаалын хавсралт

**Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал,
эрүүл ахуйн зөвлөлийн ажиллах үлгэрчилсэн журам**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөлийн зорилго нь /цаашид “Зөвлөл” гэнэ/ тухайн байгууллагын түвшинд ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгох, үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчинөөс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

1.2. Зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5.6-д заасны дагуу ажил олгогч хариуцна.

1.3. Зөвлөлийг аймаг, нийслэл, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагааныхаа талаар захиргаа, ажилтны хамт олны өмнө жил бүр тайлагнана.

1.4. Зөвлөл нь үйл ажиллагааны жилийн тайлан, мэдээг аймаг, дүүргийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлд жил бүрийн 12 дугаар сарын 15-ны дотор багтаан хүргүүлнэ.

Хоёр. Зөвлөлийн удирдлага, бүрэлдэхүүн

2.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу 20-иос дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллага бүр хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөлтэй байна.

2.2. Зөвлөлийг тухайн байгууллагын ажил олгогчийн шийдвэрээр байгуулж ажиллуулна.

2.3. Зөвлөлийг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан бутцийн нэгжийн дарга эсвэл ажилтан ахална.

2.4. Зөвлөл нь тухайн байгууллагын ажилтны тооноос хамааран ажил олгогчийн болон ажилтны төлөөллийн 3-9 хүний бүрэлдэхүүнтэй байна.

2.5. Энэхүү үлгэрчилсэн журмыг жишиг болгон зөвлөлийн ажиллах журам боловсруулж, зөвлөлийн хурлаар батлан мөрдөнө.

Гурав. Зөвлөлийн ажлын чиглэл

3.1. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийн хэрэгжилтийг байгууллагын түвшинд зохион байгуулахад оролцох;

3.2. Аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хөтөлбөр төлөвлөгөө, төсөвт тусгах асуудлыг боловсруулах, шаардлагатай дүрэм, журмыг баталж, мөрдүүлэхэд санал өгөх, хамтран ажиллах;

3.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний шалтгаан нөхцөлийн талаар хэлэлцэх, санал, зөвлөмж гаргах;

3.4. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар зөвлөгөөн, сургалт, семинар зохион байгуулах ажлыг ажил олгогчтой хамтран хийх;

3.5. Ажлын байрны эрсдэлийн үнэлгээ хийж, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлэхэд оролцох, бүртгэл судалгаатай танилцах, ажил олгогчоос шаардлагатай мэдээлэл гаргуулж авах;

3.6. Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, дүнг ажил олгогч, ажилтнуудад мэдээлэх;

3.7. Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн хангарт, хэрэглээ, ахуйн байрны орчин нөхцөл, ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт, эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байдал, түүний мөрөөр хийгдсэн эмчилгээ, сувилгаатай танилцах, хоолны чанарт хяналт тавих, үр дүнг мэдээлэх;

3.8. Аж ахуйн нэгж, байгууллагын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл, Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх орон тооны бус комиссын гишүүдийг чадавхижуулах арга хэмжээг ажил олгогчтой хамтран зохион байгуулах;

3.9. Аж ахуйн нэгж, байгууллагад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа талаар ажил олгогчийн тайлан мэдээллийг зөвлөлийн хурлаар хэлэлцэх, зөвлөмж, шийдвэр гаргах;

3.10. Хууль тогтоомжид заасан бусад асуудал;

Дөрөв. Зөвлөлийн хурал

4.1. Зөвлөл нь аж ахуйн нэгж, байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлаар хэлэлцүүлэг хийх, зөвлөлдөх, зөвлөмж, санал гаргах, шаардлага өгөх, хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулахад оролцох чиглэлээр ажил олгогч, ажилтны төлөөлөлтэй хамтран ажиллах хэлбэрээр үйл ажиллагаа явуулна.

4.2. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна.

4.3. Зөвлөлийн хурлыг нийт гишүүдийн 50-иас дээш хувийн ирцтэй хийнэ.

4.4. Зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга зарлан хуралдуулна.

4.5. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан тухайн байгууллагын холбогдох ажилтныг хуралд оролцуулж болно.

4.6. Зөвлөлийн хурлаас шаардлага, зөвлөмж гаргана. Асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэж, тэмдэглэл хөтөлнө.